

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2022 оны
12 дугаар сарын -ний өдрийн дугаар
албан бичгийн нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ЖЕНДЭРИЙН БОДЛОГЫГ 2021-2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ


АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

(2022 он)

Байгууллага: УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛЭГ

№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Хүрэх үр дүн	Тайлан
Зорилт1. Эрүүл мэндийн салбарт ажиллагчдын жендэрийн мэдлэг, хандлага, чадавхыг дээшлүүлэн мэргэшүүлж, жендэрийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлэх;				
1	2.2.1.1. Эрүүл мэндийн удирдах ажилтнууд болон бүх шатны үйлчилгээ үзүүлэгч ажилтнуудын сургалтын хөтөлбөрт жендэрийн асуудлыг тусгах, шийдвэр гаргагчдын дэмжлэгт орчин бий болгох, хүний нөөцийн чадавх бүрдүүлэх талаар	Эрүүл мэндийн салбарын бүх төрлийн мэргэжил олгох, дээшлүүлэх болон удирдах ажилтны сургалтын хөтөлбөрт жендэрийн сэдэв тусгах	Удирдах ажилтны сургалтын хөтөлбөрт жендэрийн сэдэв тусгагдсан байна	- Эрүүл мэндийн салбарт 2021-2024 онд хэрэгжүүлэх “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар баримтлах бодлого” түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд салбарын жендэрийн асуудлаар судалгаа, шинжилгээ болон мэдээлэл гаргах чадавх бүхий сургагч багш бэлтгэх сургалтад 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Нийгмийн эрүүл мэндийн ажилтан Ч.Гүнчинхорлоо хамрагдсан. 2022 оны 6 дугаар сарын 2, 3-ны өдрүүдэд зохион байгуулагдсан төрийн болон хувийн хэвшлийн эмнэлэгүүдэд ажиллаж байгаа эрэгтэйчүүдийн нарийн мэргэжлийн эмч нарт зориулсан “Жендэрийн талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, эрэгтэйчүүдийн сэтгэл зүйн онцлог хэрэгцээг нь ойлгон үр дүнтэйгээр зөвлөн туслах” арга зүйн сургалтад Бөөрний мэс заслын тасгийн урологийн эмч Б.Золбоо хамрагдсан

	олон улсын байгууллагуудтай болон бусад доноруудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх;			
Зорилт 3. Эрүүл мэндийн анхан шатны байгууллагын эмч, эмнапгийн ажиллагчдын ажиллах орчин болон иргэдэд үзүүлж байгаа тусламж, үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэй болгох замаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тэгш боломж, чанар, хүртээмжийг сайжруулах				
1	2.2.3.3. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өвөрмөц хэрэгцээ, эрсдэлт хүчин зүйлийг бууруулахад чиглэсэн эрүүл мэндийн мэргэшсэн үйлчилгээний төрлийг	Төрөлжсөн мэргэшпийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд эрэгтэйчүүдийн кабинетын (урологи, андрологи) тусламж, үйлчилгээг үзүүлдэг болсон байх	Урологи, андрологийн тусламж үйлчилгээг 2-4 эмнэлэгт үзүүлдэг болсон байна.	- Эмнэлэгт 2021 оны 05 сард Андрологийн кабинет байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна. 2022 онд нийт - Андрологи кабинетын үзлэг-174, үүнээс жижиг мэс засал болон судасны мэс засал-45 - Эр бэлэг эрхтний нөхөн сэргээх хагалгаа-15 - Гэмтлийн хагалгаа-2 - Гадна бэлэг эрхтэн томруулах мэс засал-12 - Хэвлийн арын зайгаар бөөр бүтэн авах мэс засал, хэвлийн дурангаар давсаг түрүү булчирхай авах мэс засал-64 хийгдсэн байна. 2022 онд шинээр шээсний замын чулууны мэс засал нэвтрүүлсэн.
2	үндэсний хэмжээнд хөгжүүлж, хүний нөөцийг бэлтгэх;	Төгсөлтийн дараах сургалтаар андрологийн төрөлжсөн мэргэшлийн эмчийг үе шаттайгаар бэлтгэх	Мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан эмчийн тоо	- Андрологийн мэргэшил эзэмшсэн эмчийн тоо-3 - Бөөрний мэс заслын 5 эмчийг төрөлжсөн мэргэшлийн сургалтанд сургаж байна.
Зорилт 4. Эмэгтэй, эрэгтэйчүүдийн биологийн болон нийгмийн ялгаатай хэрэгцээг харгалзсан эрүүл мэндийн жендэрийн мэдрэмжтэй мэдээлэл, сургалт, сурталчилгааг бусад салбарын оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурлан хөгжүүлэх				


1	2.2.4.1. Зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчлөлд нөлөөлж буй эрсдэлт зан үйлийн судалгаанд жендэрийн үнэлгээ хийж, мэдээлэл сургалт сурталчилгааг эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн нийгмийн ялгаатай байдалтай уялдуулан	Хүн амын дунд зохиох мэдээлэл, сурталчилгааны болон зан үйлийг өөрчлөх мэдээлэл, харилцааны ажилд улс төр, урлаг, соёл, спорт, шашны алдартнуудыг оролцуулан, сурталчлах	Хамтран ажиллаж буй байгууллагын тоо, үйл ажиллагааны тайлан	- Зүрхээ хамгаалах дэлхийн өдрийн хүрээнд зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх 2 төрлийн видео бэлтгэн эмнэлгийн цахим хуудсанд нийтлүүлсэн. Үүнд Зүрх судасны тасгийн эмч Л.Пүрэвжаргал Артерийн даралт ихсэх өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө зөвлөмжийг өгсөн бөгөөд 3300 хүний үзэлттэй, 61 хүн цааш түгээсэн байна. Зүрх судасны тасгийн эмч Д.Нямбаяр зүрх судасны өвчний эрсдэлт хүчин зүйлс сэдвээр урьдчилан сэргийлэх зөвлөгөө иргэдэд уг видео нь 2200 хүний үзэлттэй, 22 хүн цааш түгээсэн үзүүлэлттэй байна.  - Бөөрний мэс заслын тасгийн эрхлэгч А.Ханхонгор Бөөрний хавдрын үеийн тусламж мэс засал эмчилгээ, тусламж үйлчилгээний тухай эрүүл мэндийн яамны веб сайтад болон GOGO.mn мэдээлэлийн сайт тус тус мэдээлэл өгсөн. Холбоос: https://moh.gov.mn/news/5901?fbclid=IwAR1wNC_xz-IU5S_2sNqdRh2_31dpd0zxGAIUvOqMYeqw8t-0NQow04cpRA https://gogo.mn/r/nkxjm
---	---	--	--	---

			- Бөөрний мэс заслын тасгийн эрхлэгч А.Ханхонгор эмч бөөрний хортой болон хоргүй хавдрын үед хийгддэг хагалгааны тухай ямар дэвшилтэд тоног төхөөрөмж ашиглаж мэс заслын тусламж үйчилгээгээ үзүүлдэг талаар ярилцлага хүргэлээ. Видеог нийт 6000 хүн үзэж 85 хүн цааш түгээсэн /share/ байна. A screenshot of a Facebook video post. The video features a man with short dark hair and glasses, wearing a light blue medical scrub top and a lanyard with a badge. He is speaking directly to the camera against a plain light green background. The video player interface shows a progress bar at the bottom. Above the video, the text reads 'Улсын Холбоотгаар Төв Энхэлэг' and 'October 20'. Below the video, the name 'А.Ханхонгор' is displayed, followed by the title 'УХТЭ-ийн Бөөрний мэс заслын тасгийн мэс заслын эмч'. At the bottom of the post, it says 'Boost this post to reach up to 1995 more people if you spend \$14.' and 'Boost post'. Below that, it shows 'You, B. Билгүүн, Баасанбат Ганбат and 185 others' and '17 Comments 85 Shares'. - Боловсрол телевизийн эрүүл мэндийн боловсрол мэдээлэл олгодог Good Mood нэвтрүүлэгт Бөөрний мэс заслын эрхлэгч А.Ханхонгор оролцон Бөөрний үрэвсэлт өвчин сэдвээр мэдээлэл өгсөн.
--	--	--	---

				Жолооч, тээвэрчдийн эрүүл мэндийн боловсролд зориулан Хоол боловсруулах тасгийн эмч Н.Түвшинбаяр Таргалалт, түүний хор нөлөө, Архины шалтгаант элэгний өвчлөл сэдвээр видео контент оролцсон. 
3		НҮЭМ-ийн боловсрол, үйлчлэх хүрээний хүн амд олгох түүний дотор жирэмслэлтээс хамгаалахад бэлгэвчийн хэрэглээг нэмэгдүүлэх сурталчилгаа, мэдээллийг	Сурталчилгааны материал хэвлэгдсэн байна. ЖСАХ болох бэлгэвчний талаар компанит ажлууд өрнүүлсэн	2022 оны 1 сард эмэгтэйчүүдийн мэс заслын тасаг байгуулагдан зөвлөх эмч 1, эмэгтэйчүүдийн мэс заслын 3 эмч, эмэгтэйчүүдийн кабинетийн сувилагч 1 бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж эхэлсэн. 2022 онд 456 өвчтөн хэвтэн эмчлүүлсэнээс 308 өвчтөнд эмэгтэйчүүдийн мэс заслын эмчилгээ хийсэн. Эмэгтэйчүүдийн мэс заслын тасаг энэхүү өдөрлөгт тасгийн тусламж үйлчилгээг иргэдэд сурталчилж мөн нөхөн үржихүйн эрүүл мэнд, жирэмсний хяналтын ач холбогдол, БЗДХ өвчнөөс урьдчилан сэргийлэх арга зам зэрэг эрүүл мэндийн боловсрол олгох мэдээллийг

		жендэрийн мэдрэмжтэйгээр хийж, өргөжүүлэх.	байна	хүргэсэн. Нийт 60 ш гарын авлага тарааж, 20 гаруй үйлчлүүлэгч нарт зөвлөгөө мэдээлэл өгсөн. 
4		“Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулах	Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 30%-д хүрсэн байна	Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/559 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний (2021-2024 он) төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор тус эмнэлгийн эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтын үйл ажиллагааг 2022 оны 03 сарын 29 өдөр зохион байгууллаа. Сургалтаар Бөөрний мэс заслын тасгийн эрхлэгч М.Эрдэнэсайхан “Эрчүүдийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал”, Бөөр, дотоод шүүрлийн тасгийн их эмч, Б.Банзрагч “Таргалалт ба чихрийн

				шижингийн урьдал байдал” Зүрх судас судлалын тасгийн их эмч, Т.Байгалмаа “Зүрх судасны өвчний эрсдэлт хүчин зүйлс, артерийн даралт хэмжихийн ач холбогдол” тус тус сэдвүүдээр зөвлөгөө мэдээлэл хүргэлээ. Сургалтын үйл ажиллагаанд эмнэлгийн дэмжих үйлчилгээний тасгийн 16 эрэгтэй хамрагдан оролцлоо.
5		Өсвөр насны хүүхдийн нөхөн үржихүй, хүчирхийлэл, сэтгэцийн эрүүл мэнд, хоол тэжээл, осол, гэмтлэс сэргийлэх МСС олон нийтийн цахим сүлжээгээр тогтмол хийх	МСС цувралаар тогтмол зохион байгуулсан байна.	Төр мэдээллийн сайт Нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдээлэл өгөх үүднээс мэргэжлийн эмчийн зөвлөгөө ярилцлагыг Эмэгтэйчүүдийн мэс заслын тасгийн эрхлэгч АУ-ны магистр Т.Баярчимэг иргэд, эмэгтэйчүүдэд чиглэсэн зөвлөгөөг өглөө.

				 • 2022 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр ШУТИС-ийн 1-р курсын 25 оюутанд Өсвөр үе, залуучуудын бэлгийн эрүүл мэнд, БЗДХ, ДОХ/ХДХВ халдвараас сэргийлэх Нөхөн үржихүйн эрүүл мэнд, жирэмснээс хамгаалах аргууд, ТОРЧ халдвар гэж юу вэ, Умайн хүзүүний хавдар, умайн хүзүүний хавдраас урьдчилан сэргийлэх нь сэдэвт сургалт хийгдэж “Жирэмснээс хамгаалах аргууд”, “Ярина”, “Джес”, “Хөхний хавдар”, “Умайн хүзүүний эсийн шинжилгээ” гарын авлагууд 75 ширхэг тараасан. • “Охид эмэгтэйчүүдийн эрүүл мэнд”-ийн долоо хоногт зориулан 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр эмнэлгээс гадуурхи эрүүл мэндийн сургалтыг БГД-ийн “Монгени цогцолбор” сургуулийн 9-р ангийн охид, хөвгүүдэд зориулан явууллаа. Хоёр эмч, нэг сувилагч, нэг багш хамтран оролцон баг бүлгийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд нийт эмэгтэй-41, эрэгтэй-27 сурагчид оролцож, хөвгүүдэд зориулсан сургалт явуулсан нь сонирхолтой, ач холбогдолтой болж хөвгүүд асуулт асууж идэвхитэй оролцлоо. Сургалтанд:
--	--	--	--	--

				– Эмэгтэйчүүдийн эмч Т.Баярчимэг “Охидод өгөх зөвөлгөө” сэдвээр охидод хувийн ариун цэвэр, бэлгийн бойжилтын талаар сургалт хийж, асуултанд хариулж ярилцлаа. – “Сарын тэмдгийн мөчлөг” сэдвээр богино хэмжээний дүрс бичлэг үзүүлж, тайлбарлан ярилцлаа – Урологийн эмч Ө.Золбоо Хөвгүүдийн бэлгийн бойжилтын явц, гарах өөрчлөлтүүд сэдвээр сургалт хийж, асуултанд хариулж, харилцан ярилцлаа – Сувилагч Н.Баярмаа, багш Ч.Ундрахгэрэл нар сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж, хүүхдүүдэд “Охидын өврийн дэвтэр”, “Эрүүл байх нь ABCDE шиг амархан”, “Хуванцар савны хэрэглээ” сэдвээр хийсэн гарын авлага, тараах материал тараан, ярилцлага хийлээ.
--	--	--	--	---

Тайланг нэгтгэсэн ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН АЛБА

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2022 оны
12 дугаар сарын -ний өдрийн дугаар
албан бичгийн хоёрдугаар хавсралт

Улсын хоёрдугаар төв эмнэлэгт ажиллаж буй албан хаагчдын 2022 оны хүйсийн тэнцвэрт байдлын мэдээ

№	Байгууллагын нэр	Нийт		Удирдлага		Гүйцэтгэх		Туслах	
		Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм
1	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	121	399	4	0	80	312	37	87